2026он 1сар 14өдөр Дугаар 39 Улаанбаатар хот

Зээлийн багц гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, Зээлийн багц бүтээгдэхүүнээс ашиглах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 6.2 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.7.15 дахь заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Говь ХК болон Таван Богд Холдингс ХХК, Таван Богд Автомотив ХХК, Улаанбаатар Гурил ХХК, Ю Би Пи ХХК, Таван Богд Интернэйшнл ХХК, Эйрлинк Монголиа ХХК, Таван Богд Нура ХХК-уудын хамт Голомт Банктай байгуулсан 2018 оны 03-р сарын 19-ний өдрийн ЗББГС210207652/GNPLT тоот 91,000,000,000 (ерэн нэгэн тэрбум) төгрөг түүнтэй тэнцэх валютын үнийн дүнтэй, жилийн төгрөгийн 15.6%-ийн хүүтэй, долларын 9%-ийн хүүтэй зээлийн шугам, жилийн 3% хүртэлх хувийн шимтгэлтэй банкны аккредитив, баталгаа бүхий Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
   1.1. Таван Богд Холдингс ХХК нь 100%-ийн хувьцаа эзэмшдэг охин компани Таван Богд Нура ХХК-ийн 100% хувьцаа эзэмшдэг охин компани болох Таван Богд Тек ХХК болон Таван Богд Холдингс ХХК нь 100%-ийн хувьцаа эзэмшдэг охин компани Таван Богд Интернэйшнл ХХК-ийн 100% хувьцаа эзэмшдэг охин компани болох Кореа Ти Би Кэй ХХК-ийг Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд хамтран зээлдэгчээр нэмэх;
   1.2. Зээлийн багц бүтээгдэхүүний эрхээс 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийг Таван Богд Тек ХХК зээлийн шугамын зориулалтаар ашиглах;
   1.3. Зээлийн багц бүтээгдэхүүний эрхээс 72,300,000,000 (далан хоёр тэрбум гурван зуун сая) төгрөг түүнтэй тэнцэх хэмжээний валютыг Кореа Ти Би Кэй ХХК зээлийн шугам, баталгаа, аккредитивын зориулалтаар ашиглах.
2. Зээлийн багц бүтээгдэхүүний нэмэлт гэрээ болон холбогдох бусад гэрээ, бичиг баримтад Говь ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Таван Богд Холдингс ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал (Б.Оргил)-д олгосугай.
3. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД: Д.ГЭРЭЛМАА

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 2076357

Р.САРАНЦЭЦЭГ

Д.ХҮРЭЛБААТАР

GOBI

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026он 1о сар 14өдөр Дугаар 40 Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталгаажуулах тухай

Монгол Улсын Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.7.15 дахь заалт, Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмын 3 дугаар зүйлийн 3.3.1, 3.3.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Говь ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 02-р сарын 13-ны өдрийн №09 тоот тогтоолоор 2026 онд компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах, зээлийн шугамын гэрээ байгуулахыг зөвшөөрсөн сонирхлын зөрчилтэй буюу нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт болон төсвийг баталсныг дурдсугай.
2. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны 2026 оны 10-р сарын 14-ний өдрийн ээлжит хурлаар дээрх батлагдсан тогтоолын хэрэгжилттэй танилцан, 2026 оны 3-р улирлын сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлд хяналт тавьсныг үндэслэн, дараах төсөвт тусгагдаагүй бараа, ажил үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр хийгдсэн болохыг дэмжин зөвшөөрч, баталгаажуулсугай. Үүнд:

№	Компанийн нэр	Бараа, үйлчилгээ	Үнийн дүн /төгрөг/
1	Жуулчин ХХК	Аяллын үйлчилгээ	71,390,000
	Нийт		**71,390,000**

3. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД: Д.ГЭРЭЛМАА

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 №2076357

Р.САРАНЦЭЦЭГ

Д.ХҮРЭЛБААТАР